



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 1109

Сүхбаатар сум

### Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42.1.1, 42.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг хангах сумдад бүсчилсэн явуулын хурал зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгийн 1.668.030 /нэг сая зургаан зуун жаран найман мянга гучин/ төгрөгийн төсөв, сумдын хуваарийг хавсралтаар баталж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 34 дүгээр тогтоолын 3.2.14 дэх заалтын дагуу аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Зардлын тайланг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, салбар комиссын дарга /Б.Энхбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ